

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДСАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: АДГ-2021/25/-ШТА-СА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,

тэргүүлэх аудитор: Я.Самбууням

Утас: 260949

Цахим хаяг: sambuunyamyam@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 261729

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: В.Эрдэнэцогт

Утас: 261729

Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn

Гэрээт ажилтан: А.Мөнхбадрал

Утас: 261729

Цахим хаяг: munkhbadrala@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга:

Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл.....	3
Аудитын зорилт.....	3
Аудитын хамрах хүрээ.....	3
Аудитын арга зүй.....	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	3
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа.....	4
Ерөнхий мэдээлэл.....	4
БҮЛЭГ 1. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлыг төрийн захиргааны зарим байгууллага бодитой төлөвлөөгүй байна.....	6
БҮЛЭГ 2. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналт сул байна.....	7
○ Төрийн захиргааны зарим байгууллагууд нь УИХ-ын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан олгосон санхүүжилтээс төлөвлөөгүй зардал гаргасан байна.....	7
○ УИХ-ын сонгуулийн 28 дугаар тойргийн сонгуулийн хорооны нөхөн сонгуулийн зардлын тайланд тавих хяналт хангалтгүй байна.....	10
ДҮГНЭЛТ.....	11
ЗӨВЛӨМЖ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал
СТБ	Сонгуулийн төв байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг

Хүснэгтийн жагсаалт:

№	Тайлбар
Хүснэгт № 1	Нөхөн сонгуулийн зардлын төсөв
Хүснэгт № 2	УБЕГ-ын төсөв, гүйцэтгэл
Хүснэгт № 3	Болзошгүй зардлын төлөвлөлт
Хүснэгт № 4	Батлагдсан төсөв, зарцуулалт
Хүснэгт № 5	СЕХ-ны зардлын гүйцэтгэл

Дүрслэлийн жагсаалт:

№	Тайлбар
Дүрслэл № 1	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн Хэнтий 18 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн ирцийн мэдээ
Дүрслэл № 2	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн СХД-ийн 28 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн ирцийн мэдээ
Дүрслэл № 3	Төсвийн хуваарилалт тойргоор /хувиар/
Дүрслэл № 4	Төсвийн хуваарилалт байгууллагаар /хувиар/
Дүрслэл № 5	Нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэл /тойрог болон байгууллагаар/

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд аудит хийнэ”, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавин, аудит хийж, дүгнэлт гаргана” гэж тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийж дүгнэлт гаргалаа. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох санхүүжилтийг зөв төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийг зөв тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад СЕХ болон УБЕГ, ЦЕГ-т улсын төсвөөс санхүүжүүлсэн зардал, СЕХ-оос Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргийн сонгуулийн хороодод хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримт материалыг шалгах, асуулга лавлагаа авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;

- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт;

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:


Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор В.Эрдэнэцогт, гэрээт аудитор А.Мөнхбадрал нар хариуцан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:


Монгол Улсын Их Хурлын 2021 оны 61 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойрогт, 2021 оны 40 дүгээр тогтоолоор 28 дугаар тойрогт явуулах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр гэж товлон зарлаж, Сонгуулийн ерөнхий хороо зохион байгуулсан байна.

Мөн сонгуулийн ирц тавь буюу түүнээс дээш хувьд хүрээгүй нийт 131 хэсэгт 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт санал хураалт явуулахаар Сонгуулийн Ерөнхий хорооны 105 дугаар тогтоол гарч, нэмэлт санал хураалт явуулсан байна.

Дүрслэл №1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн Хэнтий аймгийн 18 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн ирцийн мэдээ



Дүрслэл №2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн СХД-ийн 28 дугаар тойрогт явагдсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн ирцийн мэдээ



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдсан Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд Монгол ардын нам, Ардчилсан нам, Дэлхийн монголчууд нам, Ард түмний олонхын засаглал нам, Үнэн ба Зөв нам, Иргэний зориг ногоон нам, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам, Зөв хүн электорат эвсэл зэрэг нийт 8 нам, 1 эвслээс 14 нэр дэвшигч, мөн бие даан 2 иргэн нэр дэвшиж нийт 16 нэр дэвшигч оролцсон байна.

Нөхөн сонгууль болон нэмэлт санал хураалтын нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн 2 сонгуулийн тойргийн хороо, сум дүүргийн 19 сонгуулийн тойргийн хороо, 148 сонгуулийн хэсгийн хороо, мэдээллийн технологийн 2 баг зэрэг нийт бүрэлдэхүүнд 1,732 хүн ажиллахаар төлөвлөж, 1,490 хүн ажилласан байна.

БҮЛЭГ 1. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг төрийн захиргааны зарим байгууллага бодитой төлөвлөөгүй байна.

1.1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 62 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 2,287.3 сая төгрөгөөр баталж, Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

1.2. Засгийн газрын 2021 оны 257 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад шаардагдах зардлын 1,845.7 сая төгрөгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн зардлын хэмнэлтээс, 444.6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн байна.

1.3. Засгийн газрын тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын 80.6 хувь буюу 1,845.7 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хороонд, 16.9 хувь буюу 386.7 сая төгрөгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт, 2.5 хувь буюу 57.9 сая төгрөгийг Цагдаагийн ерөнхий газарт хуваарилсан байна.

1.4. Дээрх байгууллагууд хуваарилагдсан төсвийг сонгогчийн тоо, сонгуулийн тойргийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ зэрэгт суурилан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3-д заасан зардлын ангиллын дагуу төлөвлөжээ.

1.5. Нийт төсвийн хуваарилалтыг диаграмм, хүснэгтээр харууллаа. Үүнд:



Хүснэгт №1. Нөхөн сонгуулийн зардлын төсөв

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагуудын нэр	18 дугаар тойрог	28 дугаар тойрог	СТБ	Нийт	Хувь
1	СЕХ	678.9	476.7	690.1	1,845.7	80.6
2	УБЕГ	199.6	187.1		386.7	16.9
3	ЦЕГ	24.2	33.7		57.9	2.5
4	Нийт	902.7	697.5	690.1	2,290.3	

5	Хувийн жин	39.4	30.5	30.1	100.0	100.0
---	-------------------	-------------	-------------	-------------	--------------	--------------

/Эх сурвалж: Сонгуулийн зардлын төсөв/

1.6. УБЕГ нь нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах нийт зардлыг сонгууль явагдах 2 тойргийн улсын бүртгэлийн хэлтэст хуваан төлөвлөж, маягт хэвлүүлэх, урамшуулал олгох, техник технологийн бэлэн байдлыг хангах зэрэгт 191.4 сая төгрөгийг төлөвлөгөөгүй зарцуулснаар тайлагнасан байна.Тухайлбал:

Хүснэгт №2. УБЕГ-ын төсөв, гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	18 дугаар тойргийн нөхөн сонгууль	199.6	97.2	(102.4)
2	28 дугаар тойргийн нөхөн сонгууль	187.1	98.1	(89.0)
3	УБЕГ		191.4	191.4
Нийт		386.7	386.7	-

/Эх сурвалж: УБЕГ-ын сонгуулийн зардлын тайлан/

1.7. Байгалийн гэнэтийн аюул, халдварт өвчин зэрэг нөхцөлөөс болж зам хаагдах, холбоо тасрах, хөл хорио тогтоох, санал авах байр нэмж байгуулах, сонгуулийн хорооны гишүүн албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдах, гэмтэж бэртсэн тохиолдолд олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, сонгуулийн техник хэрэгслийн даатгал зэрэгт гарах болзошгүй зардлыг байгууллага бүр өөр өөр хувь, хэмжээгээр тооцсон байна.

Хүснэгт №3. Болзошгүй зардлын төлөвлөлт

Байгууллага	Төлөвлөсөн болзошгүй зардал				Нийт зардал	Нийт зардалд эзлэх хувийн жин
	УИХ-ын сонгуулийн 18 дугаар тойрогт	УИХ-ын сонгуулийн 28 дугаар тойрогт	СЕХ	Дүн		
СЕХ	48.3	45.4	52.1	145.8	1,845.7	7.9
УБЕГ	4.4	4.4		8.8	386.7	2.3

/Эх сурвалж: Сонгуулийн зардлын батлагдсан хуваарь/

1.8. СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах тухай журам”-д сонгуулийн зардлын төлөвлөлт, болзошгүй зардлын тооцоолол, тайлагналын талаар тодорхой тусгаагүй байна.

БҮЛЭГ 2. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналт сул байна.

Төрийн захиргааны зарим байгууллагууд нь УИХ-ын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан олгосон санхүүжилтээс төлөвлөөгүй зардал гаргасан байна.

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 257 дугаар тогтоолоор баталсан Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах улсын төсвийн санхүүжилтийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 4. Батлагдсан төсөв, зарцуулалт


/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллага	Төлөвлөгөө	Зарцуулалт	Зөрүү
1	СЕХ	1,845.7	1,783.4	(62.3)
2	УБЕГ	386.7	386.7	-
3	ЦЕГ	57.9	57.9	-
	Нийт	2,290.3	2,228.0	(62.3)

/Эх сурвалж: Сонгуулийн зардлын тайлан/

2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн зардлын хэмнэлтээс 1,845.7 сая, Засгийн газрын нөөц сангаас 444.6 сая нийт 2,290.3 сая төгрөгийг улсын төсвөөс хуваарилснаас, гүйцэтгэлээр 2,228.0 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 62.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.3. Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг дүрслэлээр үзүүлэв. Үүнд:



/Эх сурвалж: Сонгуулийн зардлын тайлан/

2.4. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд нийт 2,228.0 сая төгрөгийн зардал гарснаас, 791.1 сая төгрөг буюу 35.5 хувийг 18 дугаар тойргийн нөхөн сонгуульд, 607.9 сая төгрөг буюу 27.3 хувийг 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд, 637.6 сая төгрөг буюу 28.6 хувийг Сонгуулийн төв байгууллагад, 191.4 сая төгрөг буюу 8.6 хувийг УБЕГ-ын /улсын бүртгэлийн хэлтсүүдээс бусад/ нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

Улсын төсвөөс санхүүжилт авсан төрийн захиргааны байгууллагуудын сонгуулийн зардлын зарцуулалтыг байгууллага тус бүрээр авч үзвэл:

1. Сонгуулийн Ерөнхий хороо:

2.5. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 257 дугаар тогтоолоор 1,845.7 сая төгрөгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой олгосон санхүүжилтийн хэмнэлтээс зарцуулахыг СЕХ-д зөвшөөрсний дагуу 1,783.4 сая төгрөгийг УИХ-ын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулж, 62.3 сая төгрөг хэмнэсэн байна. Үүнд:

Хүснэгт №5. СЕХ-ны зардлын гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
18 дугаар тойрогт	678.9	669.7	9.2
28 дугаар тойрогт	476.7	476.1	0.6
18,28 дугаар тойргийн дүн	1,155.6	1,145.8	9.8
СЕХ	690.1	637.6	52.5
Нийт	1,845.7	1,783.4	62.3

/сая төгрөгөөр/

/Эх сурвалж: Сонгуулийн зардлын тайлан/

2.6. Сонгуулийн ерөнхий хорооноос 18, 28 дугаар тойргийн сонгуулийн хороодод 1,155.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 1,145.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 9.8 сая төгрөгийг СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан *“Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.3-д “сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг СЕХ-ны дансанд эргүүлэн төвлөрүүлнэ”* гэж заасны дагуу СЕХ-д буцаан төвлөрүүлсэн байна.

2.7. Сонгуулийн ерөнхий хороо нь 18, 28 дугаар тойргийн нөхөн сонгууль зохион байгуулах өөрийн үйл ажиллагаанд 690.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 637.6 сая төгрөгийг зарцуулж, 52.5 сая төгрөгийг хэмнэсэн байна.

2.8. Энэ нь сонгууль зохион байгуулах явцад автоматжуулсан системд доголдол, гэмтэл гараагүй, хэвийн ажилласан тул болзошгүй зардал гараагүйтэй холбоотой байна.

2.9. СЕХ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- УИХ-ын нөхөн сонгуулийн зардлын төсөвт батлаагүй Засгийн газрын авто баазад авто машины үйлчилгээний төлбөрт 12.5 сая, гадаад томилолтын зардалд 3.9 сая, шатахууны талон 1.4 сая төгрөгөөр худалдаж авсан зэрэг нийт 17.8 сая төгрөгийн төлөвлөөгүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. *“ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн зардлын төсвийг батлагдсан хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих”* заалттай тус тус нийцэхгүй байна.

2.10. Сонгуулийн ерөнхий хороонд нийт 17.8 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газар:

2.11. Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явуулсан УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад Засгийн газрын нөөцөөс 386.7 сая төгрөг хуваарилсныг бүрэн зарцуулсан байна.

2.12. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 16.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэж заасныг зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4. Цагдаагийн ерөнхий газар:

2.13. Засгийн газрын нөөцөөс 18, 28 дугаар тойрогт явуулах УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад ажиллах алба хаагчдын хоол, шуудан холбоо, шатахууны зардалд 57.9 сая төгрөг хуваарилсныг бүрэн зарцуулсан байна.

2.14. ЦЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу УИХ-ын нөхөн сонгуулийн үеэр өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах алба хаагчдын хоол, шуудан холбоо, шатахууны зардалд зориулан сонгуулийн 18 дугаар тойрогт 24.2 сая, 28 дугаар тойрогт 33.7 сая нийт 57.9 сая төгрөгийг хуваарилан олгожээ.

2.15. Мөн СЕХ-оос нэмэлтээр 34.0 сая төгрөгийн хоол, шуудан холбоо, шатахууны зардал олгосныг бүрэн зарцуулсан байна.

2.16. ЦЕГ нь сонгуулийн зардлыг зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Худалдан авсан 6.0 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тайлангаа гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* заалтыг зөрчсөн;
- УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн зардлын хэмнэлтээс өөрийн үйл ажиллагаанд зориулан 4.1 сая төгрөгийн гар утасны цэнэглэгч карт худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д *"Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ"* заалтыг зөрчсөн байна.

2.17. Иймд Цагдаагийн ерөнхий газарт 6.0 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 4.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

УИХ-ын 28 дугаар тойргийн сонгуулийн хорооны нөхөн сонгуулийн зардлын тайланд тавих хяналт хангалтгүй байна.

2.18. СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан *"Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"*-ын 4.5-д *"аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргасан байна"* гэж заажээ.

2.19. Үүний дагуу Хэнтий аймгийн Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойргийн сонгуулийн хороо тус аймаг дахь Төрийн аудитын газраар УИХ-ын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын тайлангаа хянуулж, дүгнэлт гаргуулан СЕХ-д ирүүлсэн байна.

2.20. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн сонгуулийн хороо нь УИХ-ын гишүүний нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын тайлангаа Нийслэл дэх Төрийн аудитын газраар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна.

2.22. Аудитаар нийт 43.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 22.0 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж, 17.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахад оролцсон зарим төрийн захиргааны байгууллага улсын төсвөөс олгох зардлыг бодитой төлөвлөөгүй байна.
2. Сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс олгосон санхүүжилтээс төлөвлөөгүй зардал гаргасан, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
3. Сонгууль зохион байгуулахад оролцсон төрийн захиргааны байгууллагууд нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлүүд давтагдан гарсан байна.
4. Сонгууль зохион байгуулах төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах талаар эрх зүйн акт гаргаж мөрдүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Сонгуулийн Ерөнхий хороонд:

1. Сонгууль зохион байгуулах төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах талаар эрх зүйн нэгдсэн акт боловсруулж, мөрдүүлэх.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Сангийн яаманд:

1. Сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс олгох санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

УБЕГ болон ЦЕГ-т:

2. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг судалгаа, тооцоололд үндэслэн холбогдох эрх зүйн актад нийцүүлэн бодитой төлөвлөж байх;
3. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх;
4. Сонгууль зохион байгуулах санхүүжилтийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах
5. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.